



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/38

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.6.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.17 дахь заалт, “Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2 дахь заалт, мөн тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон харьяа, салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Энэ журам батлагдсантай холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2021 оны “Харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай” А/100 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Б.Батцэцэг)-д даалгасугай.



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
20~~24~~<sup>04</sup> оны 04 дугээр сарын 29 -ны өдрийн  
10:30 дугаар тушаалын хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН  
ХҮРЭЭНИЙ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь цахим хөгжил, харилцаа холбоо, салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг сайжруулах, хариуцлагыг бэхжүүлснээр яамны нэгж, харьяа салбарын байгууллагын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад оршино.

1.2. Энэ журмаар Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Монгол Улсын Их Хурлын болон Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, явц үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт болон Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх), түүний харьяа байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний салбарын байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Журмын үйлчлэх хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам (цаашид “яам” гэх) түүний харьяа байгууллага, салбарын байгууллага, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, Засгийн газрын тусгай сан (цаашид “харьяа, салбар байгууллага” гэх)-хамаарна. Үүнд:

- 1.3.1 Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар,
- 1.3.2 Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ;;
- 1.3.3 Үндэсний дата төв УТҮГ;
- 1.3.4 И-Монгол академи УТҮГ;
- 1.3.5 Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ
- 1.3.6 Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ,
- 1.3.7 Мэдээлэл холбооны сүлжээ ХХК,
- 1.3.8 Монголын цахилгаан холбоо ХК,
- 1.3.9 Монгол шуудан ХК
- 1.3.10 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
- 1.3.11 Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан
- 1.3.12 Яаманд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага  
зохион байгуулалт**

2.1. Харьяа, салбарын байгууллагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж (цаашид “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар” гэх) зохион байгуулна.

2.2. Харьяа, салбарын байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий дотоод хяналтын нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байж болно.

2.3. Яам нь энэ журмын хэрэгжилтийг хангуулах хүрээнд төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

### **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1. Харьяа, салбарын байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны баталгаажсан тайланг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлж, тус нэгж нь тайланг нэгтгэж хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь нэгтгэл тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

3.2. Харьяа, салбарын байгууллага нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг энэ журмын 2 дугаар, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг энэ журмын 3 дугаар, өөрийн байгууллагын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээг 5 дугаар хавсралтын дагуу тус тус гаргаж яаманд ирүүлнэ.

3.3. Тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтална.

3.4. Тайлан, мэдээг нь тухайн байгууллагын үйл ажиллагааны хүрсэн үр дүн, гүйцэтгэсэн ажлын чанарыг бүрэн, тодорхой илэрхийлсэн байх ба түүний үнэн, зөв эсэхийг тайлан баталгаажуулж ирүүлсэн ирүүлсэн байгууллага хариуцна.

### **Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж**

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь харьяа, салбарын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, шаардлагатай мэдээлэл, судалгаа гаргуулах, тухайн асуудлаар тайлбар, тодруулга авах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгах зэрэг хяналт-шинжилгээ, үнэлгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

4.2. Энэ журмын 2,3 дугаар хавсралтын дагуу харьяа, салбарын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлнэ.

4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь харьяа, салбарын байгууллагаас ирүүлсэн тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтуудын дагуу нэгтгэн ерөнхий дүнг гаргана.

4.4. Ерөнхий дүнг гаргахдаа энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан шалгуур үзүүлэлт бүрийн хувиар илэрхийлсэн үнэлгээний нийлбэрийг нийт шалгуур үзүүлэлтийн тоонд хувааж дундаж оноогоор үнэлнэ.

4.5. Ерөнхий дүнг дараах байдлаар үнэлж, дүгнэнэ. Үүнд:

- 4.5.1. 90-100 хувьд харгалзах дүнтэй бол “маш сайн”;
- 4.5.2. 70-89 хүртэлх хувьд харгалзах дүнтэй бол “хэвийн”;
- 4.5.3. 69-өөс доош хувьд харгалзах дүнтэй бол “хангалтгүй”;

4.6. Харьяа, салбарын байгууллага нь тайлан, мэдээгээ энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд ирүүлээгүй бол “хангалтгүй” гэж дүгнэнэ.

4.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь харьяа, салбарын байгууллагын тайланг үнэлж, дүгнэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад танилцуулна.

4.8. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

4.8.1. жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “маш сайн”, “хэвийн” дүгнэгдсэн харьяа, салбарын байгууллагын удирдлагыг урамшуулах, төрийн дээд болон салбарын шагналд тодорхойлох;

4.8.2. жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “хангалтгүй” дүгнэгдсэн харьяа, салбарын байгууллагын удирдлагад хугацаатай үүрэг даалгавар өгөх, сахилгын шийтгэл ногдуулах, шаардлагатай тохиолдолд бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

4.9. Энэ журмын 4.3-д заасан ерөнхий дүн нь харьяа байгууллагын захирлын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн үнэлгээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-д заасан салбарын төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн компанийн захирлын “Харьяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллагын үнэлгээ (шийдвэрийн хэрэгжилт)”-ын үнэлгээ болно.

#### **Тав. Санал, зөвлөмжийг хүргүүлэх**

5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын шийдвэр гарснаас хойш хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал зөвлөмжийн хувийг харьяа, салбарын байгууллагад ажлын 5 хоногт багтаан хүргүүлэх ба яамны цахим хуудаст ил тод байршуулна.

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас харьяа захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, салбарын төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн хуулийн этгээдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

#### **Зургаа. Бусад**

6.1. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-аар зохицуулна.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ,  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛГНАХ ХУГАЦАА**

№	Тайлангийн төрөл	Тайллан хүргүүлэх хугацаа	Давтамж
1	2	3	4
Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр	01.15, 06.15	Явцыг хагас жил тутам
Бодлогын баримт бичиг	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	12.05 12.01, 06.02 12.01, 05.25	Жил тутам Явцыг хагас жил тутам Явцыг хагас жил тутам
Байгууллагын үйл ажиллагааны байгууллага/	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /Төрийн захиргааны байгууллага/	01.20, 06.15	Явцыг хагас жил тутам
Бизнес төлөвлөгөөний биелэлт /ГУЗ-тай байгууллага/ Контрактын гэрээний биелэлт (жилдээ) /ТӨБЗГ-тай гэрээ байгуулдаг байгууллага/	Бизнес төлөвлөгөөний биелэлт /ГУЗ-тай байгууллага/ Контрактын гэрээний биелэлт (жилдээ) /ТӨБЗГ-тай гэрээ байгуулдаг байгууллага/ Стратеги төлөвлөгөөний биелэлт (жилдээ)	01.20, 06.15 01.20, 06.15 01.20, 06.15	Явцыг хагас жил тутам Явцыг хагас жил тутам Явцыг хагас жил тутам
Хяналт-шинжилгээ, үнэлгээний санал, зөвлөмжийн биелэлт Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээлэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээний санал, зөвлөмжийн биелэлт Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээлэл	Зөвлөмжид заасан хугацаанд Улирал бурийн дараа сарын 05	- Явцыг хагас жил тутам
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Шилэн дансны хөтөллийн үнэлгээ /Шилэн дансны тухай хуульд заасан хугацаагаар/ Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	Шилэн дансны тухай хуульд заасан хугацаагаар 02.01	Явцыг хагас жил тутам Жил тутам

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ**

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удаширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Салбар чиглэл: 1					
1.а. Монгол Улсын хууль					
1.б. Улсын Их Хурлын тогтооп					
1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
1.д. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Тэмдэглэл					
1.е. Засгийн газрын тогтоол					
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					

1.3. Засгийн газрын албан даалгавар	
Хэсгийн дундаж: .... хувь	
Салбар чиглэл: 2	
2.а. Монгол Улсын хууль...	
Хэсгийн дундаж: .... хувь	
Нийт дундаж: .... хувь	

Тайлан, мэдээ гаргасан:  
.....ын захидал(.....) нэр (.....) гарын үсэг

Огноо.....

Журмын гуравдугаар хавсралт

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУСНЭГТ**

№	Үндэслэлж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгур Үзүүлэлт	Сурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буоу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				ОН	Түвшин		
<b>Бодлогын баримт бичгийн зорилго 1</b>							
1.	Зорилт 1						
1.1.	Арга хэмжээ						
1.2.	Арга хэмжээ						
1.3.	Арга хэмжээ						
<b>Бодлогын баримт бичгийн зорилго 2</b>							
2.	Зорилт 2						
2.1.	Арга хэмжээ						
2.2.	Арга хэмжээ						
2.3.	Арга хэмжээ						

Тайлан, мэдээ гаргасан:

.....ын захидал(.....) нэр (.....) гарын үсэг

Огноо.....

## ХАРЬЯА ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГДАНЫ ҮНЭЛГЭЭ

		20 ... онд төлөвлөсөн нийт арга хэмжээний тоо	Үнэлгээ Хувь
Бодлогын баримт бичийн хэрэгжилтийн үнэлгээ	Шалгуур үзүүлэлт  Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө		
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр		
Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ	Стратеги төлөвлөгөөний биелэлт  Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Хяналт-шинжилгээ, Үнэлгээний санал, зөвлөмжийн биелэлт  Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээлэл  Нээлттэй мэдээллийн-илт тод байдлын үнэлгээ  Шилжэн дансны хөтөлгөлийн үнэлгээ		
		ЕРӨНХИЙ ДҮН	

## ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Маягт 2.

	Шалтуур үзүүлэлт	20 ... онд төлөвлөсөн нийт арга хэмжээний тоо	Үнэлгээ Хувь
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө		
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр		
Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ	Контрактын гэрээний биелэлт (жилдээ) Салбарын бодлого хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт Хяналт-шинжилгээ, үнэлгээний санал, зөвлөмжийн биелэлт		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Нийтэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, статистик мэдээлэл Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ		
		<b>ЕРӨНХИЙ ДҮН</b>	

**Маягт 3.**

**ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ**

	Үзүүлэлт	20 ... онд төлөвлөсөн НИЙТ арга хэмжээний тоо	Үнэлгээ Хувь
1.	Бизнес төлөвлөгөөний биелэлт		
2.	Хяналт-шинжилгээ, Үнэлгээний санал зөвлөмжийн биелэлт		
3.	Нийгэм, эдийн засгийн хөгжлийн Үзүүлэлт, статистик мэдээлэл		
4.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын Үнэлгээ		
	<b>ЕРӨНХИЙ ДҮН</b>		

Журмын тавдугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН  
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН 20.. ОНЫ ...-Р УЛИРЛЫН  
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх улирал	Тайлант улирал	Тайлбар
<b>1. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар</b>					
Төрийн цахим үйлчилгээний цэг					
1.	Нийслэл	Too			
2.	Орон нутаг	Too			
3.	Хилийн боомт	Too			
Төрийн цахим үйлчилгээний цэгээр үзүүлсэн үйлчилгээний тоо					
1.	Нийслэл	Too			
2.	Орон нутаг	Too			
3.	Хилийн боомт	Too			
4.	Хилийн чанад	Too			
Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах ажлын хүрээнд зохион байгуулсан сургалт					
1.	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын тоо	Too			
Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан хүн, хуулийн этгээд					
1.	Төрийн албан хаагч	Too			
2.	Иргэд	Too			
3.	Ерөнхий боловсролын сургууль	Too			
Гадаад улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт					
1.	Үйлчилгээний албан хаагч	Too			
Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт					
1.	Сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
2.	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан албан хаагчид	Too			
3.	Хөрөнгө оруулалт	Too			
4.	Нийт ажилтан	Too			
5.	Ажилтан /эм/	Too			
<b>2. Радио, телевизийн сүлжээ УТҮГ</b>					
Олон нийтийн үйлчилгээ					
1.	Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хэрэглэгч				
	Баруун бүс	Too			
	Хангайн бүс	Too			
	Төвийн бүс	Too			
	Зүүн бүс	Too			
	Улаанбаатар	Too			
2.	Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хэрэглэгч				
	Баруун бүс	Too			
	Хангайн бүс	Too			
	Төвийн бүс	Too			
	Зүүн бүс	Too			
	Улаанбаатар	Too			
3.	Тасралт, гэмтэл саатал				

	Хиймэл дагуулаар дамжуулах сүлжээний тоног төхөөрөмжийн /МонголСат Нэтворкс ХХК-с шалтгаалсан/	Too			
	РТҮС УТҮГ-ЫН тоног төхөөрөмжийн өөрөөс шалтгаалсан/	Too			
	Бусад /үүнд эфирийн гэмтэл саатал/	Too			
4.	Шуурхай удирдлагын төвд ирсэн хэрэглэгчийн гомдол шийдвэрлэсэн	Too			
5.	Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний чанар : Хамрах хүрээг өргөтгөсөн сайт	Too			
6.	Антены тохиргоо хийсэн сайт	Too			
7.	РТС-ний операторын хэрэглэгчид өгсөн үйлчилгээ (Зөвлөмж, хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийн тохиргоо, мэдээ мэдээлэл)	Сая/төг			
8.	Стандарт шаардлага хангасан байр талбай бүхий сайт	Too			
<b>Түрээсийн үйлчилгээ</b>					
9.	Телевизийн дахин дамжуулах үйлчилгээ	Too			
10.	Байр талбай түрээсийн үйлчилгээ	Too			
11.	Антен цамхаг түрээсийн үйлчилгээ	Too			
12.	Орчуулгын төхөөрөмж түрээсийн үйлчилгээ	Too			
13.	Зөөврийн өсгөгч түрээсийн үйлчилгээ	Too			
<b>Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт</b>					
14.	Мэргэшүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
15.	Мэргэшүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдагсад	Too			
16.	Хөрөнгө оруулалт	Сая/төг			
17.	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	Сая/төг			
18.	Нийт ажилтан	Too			
19.	Ажилтан /Эм/	Too			
<b>3. Үндэсний дата төв УТҮГ</b>					
<b>Төрийн байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ</b>					
1.	Төрийн байгууллагад домэйн нэр олгох үйлчилгээ	Too			
2.	Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах үйлчилгээ	Too			
3.	Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ	Too			
4.	Төрийн үйлчилгээний цахим (түц) машинд холбох үйлчилгээ	Too			
5.	Төрийн мэдээлэл солилцооны системд холбох үйлчилгээ	Too			
6.	Төрийн албан хаагчид тоон гарын үсэг олгох үйлчилгээ	Too			
7.	"Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем"-д холбох үйлчилгээ	Too			
8.	Үндэсний цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ	Too			
<b>Хувийн байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ</b>					
9.	Хувийн хэвшилд үзүүлж буй үйлчилгээ	Too			
10.	Хувийн хэвшлийн үйлчлүүлэгчид	Too			
11.	Зохиомол сервер түрээсийн үйлчилгээ	Too			

12.	Төрийн мэдээлэл солилцооны системд холбох үйлчилгээ	Too			
13.	Зогсуур түрээсийн үйлчилгээ	Too			
14.	Сервер тоног төхөөрөмж байршуулах үйлчилгээ	Too			
15.	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийсэн	Too			
16.	Интернэтийн харилцан холболтын үйлчилгээ	Too			
17.	Байгууллагын мэдээллийн сан байршуулах үйлчилгээ	Too			
18.	Тасралт, саатал	Too			
19.	Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ	Too			
20.	Зохиомол сервер түрээсийн үйлчилгээний тоо	Too			
Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт					
21.	Сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
22.	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан	Too			
23.	Хөрөнгө оруулалт	Сая/төг			
24.	Улсын төсөөт төвлөрүүлсэн орлого	Сая/төг			
25.	Нийт ажилтан	Too			
26.	Ажилтан /эм/	Too			
<b>4. И-Монгол академи УТҮГ</b>					
1.	Үндсэн систем үүнээс:	Too			
	И-Монгол системийн бүртгэлтэй хэрэглэгч	Too			
	И-монгол систем ашигласан хэрэглэгч	Too			
	И-Монгол системд нэвтэрсэн үйлчилгээ	Too			
	И-Монгол системийн үйлчилгээний хандалт /Мобайл, портал, оператор/	Too			
	И-Монгол системийн Орон нутгийн үйлчилгээ	Too			
	Мэдэгдэл хүргэх систем/messenger, үндэсний и-мэйл, хувийн и-мэйл, push notification/	Too			
	Lavlagaa.e-mongolia.mn систем/ хэрэглэгчийн оператор, хэрэглэгч байгууллага/	Too			
	Lavlagaa.e-mongolia.mn систем/төлбөртэй лавлагаа, нийт авсан лавлагаа/	Too			
	ХҮР систем/ сервисийн тоо/	Too			
2.	ХҮР системд холбогдсон байгууллагын тоо /Төрийн, хувийн/	Too			
	Бусад систем үүнээс:				
	egr.e-mongolia.mn систем/холбогдсон байгууллага, бүртгэлтэй хэрэглэгч,	Too			
	docx.gov.mn систем /холбогдсон системийн тоо, холбогдсон байгууллагын тоо,	Too			
	docx.gov.mn систем/солилцсон бичиг (ирсэн, явсан, файл)	Too			
3.	sudalgaas.gov.mn систем/холбогдсон байгууллага, нийт хэрэглэгч, нийт судалгаа/	Too			
	opendata.gov.mn систем/холбогдсон байгууллага, нийт хэрэглэгч, нийт өргөдөл/	Too			
	huduu.mn портал /нийт хандалт, хэрэглэгч байгууллага/	Too			
	e-sign.gov.mn тоон гарын үсгийн мэдээлэл/ төр, хувь/	Too			
	Төрийн байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ үүнээс:				
Хүр системд Төрийн байгууллагын холбогдсон тоо		Too			

	Төрийн үйлчилгээг цахимжуулах процесийн судалгаа	Too			
	Төрийн байгууллагад ашиглаж буй цахим системийн судалгаа	Too			
4.	Төрийн албан хаагчдын сургалт үүнээс:				
	Нийслэл	Too			
	Орон нутаг	Too			
	Сургалтын контент	Too			
5.	Олон нийтийн үйлчилгээ үүнээс:	Too			
	1111-2 Дуудлагын төвд ирсэн, TelcoCom системийн тайланда бүртгэгдэж буй алдагдалгүй дуудлага	Too			
	1111-2 Дуудлагын төвд ирсэн Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт	Too			
	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээ	Too			
6.	Олон нийтийн байгууллагыг мэдээллээр хангасан үйл ажиллагаа	Too			
	Сургалтад хамруулсан иргэд үүнээс:	Too			
	Нийслэл	Too			
	Орон нутаг	Too			
7.	Сургалтын контент	Too			
	Иргэд, олон нийтийг хамруулсан сургалт үүнээс:	Too			
	Нийслэл	Too			
	Орон нутаг	Too			
8.	Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт үүнээс:	Too			
	Мэргэшүүлэх дээшлүүлэх сургалт, зохион байгуулсан арга хэмжээ	Too			
	Мэргэшүүлэх дээшлүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдсан албан хаагчид	Too			
	Хөрөнгө оруулалт	Сая/төг			
	Нийт ажилтан	Too			
	Ажилтан /Эм/	Too			
<b>5. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ</b>					
	Иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ				
1.	Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хүлээн авч, зөвлөмж хургуулсэн	Too			
2.	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хүлээн авч, зөвлөмж хургуулсэн	Too			
3.	Иргэд олон нийтэд кибер аюулгүй байдлын талаар мэдээлэл сурталчилгаа түгээсэн	Too			
4.	Иргэдэд тулгарсан халдлага, зөрчлийг илрүүлсэн	Too			
5.	Иргэдэд тулгарсан халдлага, зөрчилд хариу үзүүлсэн	Too			
6.	Халдлага, зөрчлийн талаар дуудлага хүлээн авсан	Too			
7.	Халдлага, зөрчлийг нөхөн сэргээсэн	Too			
8.	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
9.	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн	Too			
	Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт				

1.	Сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
2.	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан	Too			
3.	Хөрөнгө оруулалт	Сая/төгрөг			
4.	Нийт ажилтан	Too			
5.	Ажилтан /эм/	Too			
6.	Ажилтан /эр/	Too			

#### 6. Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ

	Үндсэн үйлчилгээ				
	Олон улсын шалгалтад хамрагчид үүнээс:				
1.	МТИШ-д	Too			
	ТОПСИТ-д	Too			
	ICDL-д	Too			
2.	Олон улсын шалгалтад тэнцэгчид, үүнээс:				
	МТИШ-д	Too			
	ICDL-д	Too			
3.	МТ чиглэлийн сургалт үүнээс:				
	МТИШ-д бэлтгэхээр зохион байгуулсан сургалт	Too			
	Хүүхдүүдэд технологи боловсрол олгохоор зохион байгуулсан сургалт	Too			
	Хүүхдүүдэд технологийн боловсрол олгохоор зохион байгуулсан сургалт	Too			
	Бусад зохион байгуулсан сургалт	Too			
4.	МТ-ийн чиглэлийн сургалтад хамрагчид үүнээс:				
	МТИШ-д бэлтгэх сургалтад хамрагчид	Too			
	Хүүхдүүдэд технологийн боловсрол олгох сургалтад хамрагчид	Too			
	Бусад сургалтад хамрагчид	Too			
5.	Танхим ашиглалт үүнээс:				
	Танхим ашиглалтын орлого	Сая/төгрөг			
	Танхимын үйлчилгээ авсан тоо	Too			
6.	МТ-ийн бизнесийг дэмжих үйлчилгээ үүнээс:				
	Инкубаторт элсэх хүсэлт гаргагчид зориулан зохион байгуулсан семинар	Too			
	Инкубаторт элсэх хүсэлт гаргасан баг, аж ахуйн нэгж	Too			
	Нийт инкубаторт элссэн	Too			
	Инкубаторт нийт бойжиж гарсан	Too			
	Инкубаторын хүний нөөц	Too			
	Инкубаторт одоо бойжиж байгаа	Too			
7.	Инновацын дэлгүүр үүнээс:				
	Инновацын дэлгүүрийн орлого	Сая/төгрөг			
	Инновацын дэлгүүрийн бүтээгдэхүүн	Too			
8.	Инновац, технологийг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээ	Too			
9.	Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт:				
	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ	Too			
10.	Сургалтад хамрагдсан албан хаагчид	Too			
11.	Хөрөнгө оруулалт	Сая/төгрөг			
12.	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	Сая/төгрөг			
13.	Нийт ажилтан	Too			
14.	Нийт ажилтан /эм/	Too			

#### 7. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

1.	Улс хоорондын сүлжээний багтаамж,	Gb			
----	-----------------------------------	----	--	--	--



7.	Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт	Too			
8.	Сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	Too			
9.	Сургалт, арга хэмжээнд хамрагдсан албан хаагчид	Too			
10.	Хөрөнгө оруулалт	Сая/төг			
11.	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	Сая/төг			
12.	Нийт ажилтан	Too			
13.	Ажилтан /эм/	Too			
<b>9. Монгол шуудан ХК</b>					
Шуудан хүргэлт үүнээс:					
1.	Нийслэл	Too			
	Аймаг	Too			
	Сум	Too			
	Баг	Too			
Шуудан хүргэлт ангиллаар үүнээс:					
2.	Нийт солилцоо	Too			
	Дотоод солилцоо/орох	Too			
	Дотоод солилцоо/гараах	Too			
	Улс хооронд солилцоо /орох	Too			
	Улс хооронд солилцоо /гараах	Too			
	Нийт солилцооны өсөлт, бууралтын хувь	Too			
Дотоодын шуудан хүргэлт үүнээс:					
3.	Нийслэл	Too			
	Хот хооронд	Too			
	Аймаг хооронд	Too			
	Аймаг, сум хооронд	Too			
	Сум, баг хооронд	Too			
Дотоодын шуудан хүргэлт ангиллаар үүнээс:					
4.	Сонин, хэвлэл /ном, сурх бичиг, зар сурталчилгааны материал /	Too			
	Бичиг захидал	Too			
	Илгээлт, боодол	Too			
	Төрийн цахим үйлчилгээний баримт, бичиг	Too			
	Онлайн худалдааны хүргэлт	Too			
	Бусад	Too			
Шуудангийн үйлчилгээний төрөл үүнээс:					
5.	Уламжлалт үйлчилгээний нэр, төрөл	Too			
	Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ	Too			
	Шуудангаар дамжих нийгэмд чиглэсэн үйлчилгээний нэр, төрөл /socially-oriented services through post	Too			
Шуудангаар үйлчлүүлэгчид үүнээс:					
6.	Ухаалаг шуудангаар үйлчлүүлэгчид	Too			
	Энгийн шуудангаар үйлчлүүлэгчид	Too			
	Хурдавчилсан шуудангаар үйлчлүүлэгчид	Too			
	Буухиа шуудан	Too			
	Логистик үйлчилгээгээр үйлчлүүлэгчид	Too			
Шууданг тээвэрлэж буй төрлөөр /богцны тоо, жин/ үүнээс:					
7.	Олон улсад /агаараар	Too			
	Олон улсад /газраар	Too			
	Улаанбаатарт /өөрийн тээврээр	Too			
	Төмөр замаар	Too			

	Хот хоорондын тээврээр/гэрээт	Too			
	Агаарын тээврээр	Too			
8.	Шинээр хэвлүүлсэн маркийн сэдэв				
	Үүнээс:	Үндсэн	Too		
		Нэмэлт	Too		
	Арилжааны болон төлбөрийн зориулалттай бусад тэмдэгтийн үлдэгдлийн өөрчлөлт	Too			
	Улсын фондын маркийн үлдэгдлийн өөрчлөлт	Too			
9.	Ажилтан, ажиллагсад үүнээс:				
	Нийт ажилтан	Too			
	Үндсэн ажилтан	Too			
	Гэрээт ажилтан	Too			
	Эмэгтэй ажилчид	Too			
	Удирдах шатанд ажиллаж байгаа эмэгтэй ажилчид	Too			
	Нийт ажилтнаас шуудан хүргэлтийн ажилтны хувь	Too			
	Ажиллагсдын дундаж цалин	Tөг			
10.	Хүргэлтийн хугацаа үүнээс				
	Хотод илгээмж цуглуулах /box collection/ өдрийн дундаж	Too			
	Хөдөө орон нутагт илгээмж цуглуулах өдрийн дундаж	Too			
11.	Гэрээт шуудан тээвэрлэгч харилцагчид үүнээс:				
	Байгууллага	Too			
	Иргэд	Too			
12.	Шуудангийн хайрцаг үүнээс:				
	Өрх гэр	Too			
	Байгууллага	Too			
	Нийслэлд	Too			
	Орон нутагт	Too			
13.	Лавлагаа үүнээс:				
	Лавлагаа орлого	Tөг			
	Нийт орлого	Сая/төг			
	Улс хоорондын /орох, гарах/	Too			
	Дотоодын /орох, гарах/	Too			
	Цахим худалдааны хүргэлтийн орлого	Tөг			
	Хүргэлтийн үйлчилгээний орлого	Сая/төг			
14.	Зардал үүнээс:				
	Техник хангамж сайжруулсан зардал	Сая/төг			
	улсын фондын маркийн хадгалалт, хамгаалалтын зардал	Сая/төг			
	Нийт зардал	Сая/төг			
15.	Хөрөнгө оруулалт	Сая/төг			
16.	Улсын төсөөт төвлөрүүлсэн орлого	Сая/төг			
<b>10. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан</b>					
Үндсэн үйл ажиллагаа					
1.	Тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт	хувь			
Эдийн засаг, хүний нөөцийн үзүүлэлт					
1.	Төвлөрүүлсэн орлого	Сая/төг			
2.	Сангийн зарцуулалт	Сая/төг			
<b>11. Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан</b>					
Үндсэн үйл ажиллагаа					
1.	Тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт	Хувь			

Эдийн засаг хүний нөөцийн үзүүлэлт

1. Сангийн зарцуулалт

Сая/төг